



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 08/20

Улаан-Уул

«Энгийн болон ахуйн хог хаягдлын төлбөр
хураамжийг шинэчлэн тогтоох тухай»

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3, 35 дугаар зүйлийн 35.1.10, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2, Татварын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 8 дугаар хуралдаанаас ТОГТООХ нь;

1. Сумын нутаг дэвсгэрт оршин сууж буй айл өрх, аж ахуйн нэгж, үйлдвэр үйлчилгээний газрууд, албан байгууллагуудаас гарч буй энгийн болон ахуйн хог хаягдлыг ачиж, тээвэрлэн зайлуулах, булшлах ажлын үйлчилгээний төлбөр хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Хог хаягдлыг ачиж тээвэрлэх жолооч нартай гэрээ байгуулан, график гарган цаг хугацаанд нь ачуулах, тэдний нийгмийн болон хөдөлмөр хамгаалал, цалин урамшууллыг шийдвэрлэж ажиллахыг сумын Засаг дарга (Т.Эрдэнэбат)-д даалгасугай.

3. Батлагдсан тарифыг мөрдүүлэн хэрэгжүүлж төлбөр, хураамжийг бүрэн төвлөрүүлж ажиллахыг сумын Засаг дарга (Т.Эрдэнэбат), татварын улсын байцаагч (Г.Эрдэнэсан) нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 16/03 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

5. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Д.Нарантуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ГОНГОР

Ёсчилсон 2022 оны 06 сарын 03 ны өдөр

648801011

D:\dok\ИТХ-8 дахь удаагийн сонгууль\8-р хуралдаан\тогтоол.docx

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит
8 дугаар хуралдааны 2022 оны 06 дугаар сарын 03-ны
өдрийн 08/20 дугаар тогтоолын хавсралт

ЭНГИЙН БОЛОН АХУЙН ХОГ ХАЯГДЛЫГ АЧИЖ,
ТЭЭВЭРЛЭН ЗАЙЛУУЛАХ, БУЛШЛАХ АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ТӨЛБӨР ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Хог хаягдал гаргах эх үүсвэр	Ачих сарын тоо	Төлбөрийн хэмжээ	Аж ахуйн нэгж, байгууллага, өрхийн тоо	Жилд төлөх төлбөрийн хэмжээ /төгрөг/
1	2	3	4	5	6
1	Айл өрх	12	5000	180	10,800,000
2	Засаг даргын Тамгын газар	12	20000	1	240,000
3	Сургууль	12	30000	1	360,000
4	Цэцэрлэг	12	20000	1	240,000
5	Эмийн сан	12	10000	1	120,000
6	Эрүүл мэндийн төв	12	30000	1	360,000
7	Соёлын төв	12	20000	1	240,000
8	Шатахуун түгээх станц	12	50000	2	1,200,000
9	Дэлгүүр	12	20000	5	1,200,000
10	Ресторан, бар, хоолны газар	12	25000	1	300.000
11	Банк санхүүгийн алба	12	20000	2	480.000
12	Холбоо	12	5000	1	60.000
13	Уул уурхай болон бусад зориулалтаар үйл ажиллагаа явуулж буй кемп, уурын зуух	Үйл ажиллагаа явуулж байгаа үед	100.000		
14	Үйлдвэр эрхлэгч иргэн аж ахуйн нэгж	12	25000		
15	Аялал жуулчлал, амралт сувилал	4	40000		
16	Аялал жуулчлалын бүс газруудад амарч зугаалж байгаа иргэдээс	Хоногт 1 хүн	1000		
Төв суурин айл өрх, аж ахуйн нэгж байгууллагаас нийт авах хураамж					15,600,000
16	Хөдөөгийн малчин өрхөөс хог хаягдлын хураамж авах	Жилд нэг удаа	10000	600	6000000